



ХОВД АЙМАГ ДАХЬ  
САЛБАР СУРГУУЛЬ

ᠬᠣᠪᠳᠠ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ  
ᠰᠠᠯᠪᠠᠷ ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠤ



## ХОВД ХОТЫН НОГООН БАЙГУУЛАМЖ





ХОВД АЙМАГ ДАХЬ  
САЛБАР СУРГУУЛЬ

Ховд хот нь далайн түвшнээс дээш 1405 метрийн өндөрт оршдог. Эх газрын шинжтэй эрс тэс уур амьсгалтай. Чийгийн үзүүлэлтээрээ хуурай дулаавтар, уул хээрийн мужид байдаг. Улаанбаатар хотоос 1460 км, аймгийнхаа бусад сумаас 25-375 км зайтай, Буянт, Ховд, Дуут сумуудтай хил залгаа оршдог. Буянт голын сав нутгийн нэг хэсэг болох Монгол Алтайн нуруу нь чийглэгдүү сэрүүн бүсийн хахир хүйтэн мужид хамаарагдана. Их нууруудын хотгорт багтах Буянт голын сав нутаг нь нэн хуурай, дулаан бүсийн хүйтэн мужид хамаарагдана. Эндээс буянт голын сав нутаг нь уур амьсгалын 2 үндсэн мужид хамаарагдана.

## ОРШИЛ

- Ховд хот нь Монгол улсын баруун хэсэгт оршдог Ховд аймгийн төв бөгөөд Монгол Алтайн нурууны бэлд, Буянт голын эрэг дээр оршдог. 1992 оноос хойш Ховд хот нь Жаргалант сум нэртэй болсон.
- Ховд хот нь далайн түвшнээс дээш 1405 метрийн өндөрт оршдог. Эх газрын шинжтэй эрс тэс уур амьсгалтай. Чийгийн үзүүлэлтээрээ хуурай дулаавтар, уул хээрийн мужид байдаг. Улаанбаатар хотоос 1460 км, аймгийнхаа бусад сумаас 25-375 км зайтай, Буянт, Ховд, Дуут сумуудтай хил залгаа оршдог.
- Буянт голын сав нутгийн нэг хэсэг болох Монгол Алтайн нуруу нь чийглэгдүү сэрүүн бүсийн хахир хүйтэн мужид хамаарагдана. Их нууруудын хотгорт багтах Буянт голын сав нутаг нь нэн хуурай, дулаан бүсийн хүйтэн мужид хамаарагдана. Эндээс буянт голын сав нутаг нь уур амьсгалын 2 үндсэн мужид хамаарагдана.







ХОВД АЙМАГ ДАХЬ  
САЛБАР СУРГУУЛЬ

## Ховд хотын ногоон байгууламж хариуцсан байгууллага



Ховд аймаг нь хотын ногоон байгууламжийг хариуцдаг албан байгууллагатай. Хот тохижуулах газар нь анх 1996 онд Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хотын доторх тохижилт соёлжилт хариуцсан **“ХОТ ТОХИЖИЛТ ИРГЭДЭД ҮЙЛЧЛЭХ ГАЗАР”** нэртэйгээр 21 ажилтан албан хаагчидтай байгуулагдаж байсан.

Тухайн байгууллагын чиг үүрэг нь нийтийн эзэмшлийн гудамж талбай цэвэрлэх, хог хаягдал захиалгын дагуу ачиж төвлөрсөн хотын цэгт буулгах, иргэдэд буяны үйлчилгээ үзүүлэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэж байсан.





ХОВД АЙМАГ ДАХЬ  
САЛБАР СУРГУУЛЬ

Ховд аймаг дахь  
салбар сургууль

2007 онд Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор бүтэц орон тоог шинэчлэн Хот тохижилт иргэдэд үйлчлэх газрыг татан буулган **“ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА”** нэртэй байгуулж бүтэц орон тоог нь 20 ажилтантай ажиллахаар тогтоосон.

Тухайн байгууллагын ажлын чиг үүрэг нь нийтийн эзэмшлийн гудамж талбай цэвэрлэх, гудамж талбайн гэрэлтүүлэг, аж ахуй нэгж албан байгууллага, эзэнгүй хог хаягдал цэвэрлэж ачиж зайлуулах ажлыг хийж гүйцэтгэж байсан

2013 оны 3 сарын 22–ны өдрийн Аймгийн иргэдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор Захирагчийн ажлын алба татан буулгаж **“ХОВД ЭРЧ ХҮЧ ОНӨААТҮГ”** болгон 22 хүний орон тоотойгоор шинэчлэн баталсан..

Энэ байгууллагын ажлын чиг үүрэг нь хотын дотор ногоон байгууламж, гудамж талбайн гэрэлтүүлэг, хотын тохижилт үйлчилгээ, аж ахуй нэгж албан байгууллагын хог, эзэнгүй хог хаягдал цэвэрлэж ачиж зайлуулах ажлыг хийж гүйцэтгэж байсан





ХОВД АЙМАГ ДАХЬ  
САЛБАР СУРГУУЛЬ

Ховд аймаг дахь  
салбар сургууль

2017 оны 07 сарын 17 өдөр Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор  
Ховд эрч хүч ОНӨААТҮГазрыг татан буулгаж “Хот тохижуулах газар”-ыг үүсгэн  
байгуулсан.

Хотын ногоон  
байгууламж

Байгаль орчин  
нөхөн сэргээх

Нийтийн  
эзэмшлийн  
гудамж талбайн  
гэрэлтүүлэг

2 дендерлогич, 7 цэцэрлэгжүүлэгч





ХОВД АЙМАГ ДАХЬ  
САЛБАР СУРГУУЛЬ

Ховд хотын ногоон байгууламж

## Ховд хотын ногоон байгууламж

- Ховд хот нь хуурай уур амьсгалтай учраас хуурай нөхцөлд дассан зохицсон нутгийн уугуул болон хил залгаа ОХУ, Хятадаас улсаас оруулж ирдэг мод бутыг тариалдаг.
- Ховд хотын нийтийн эзэмшлийн 19213,76 м<sup>2</sup> талбай бүхий 260 тагт, саданд шилмүүст мод-47, жодоо-2, шар хуайс-201, нохойн хошуу-11, хайлаас-3421, улиас-262, голт бор-1, зэгд-2, агч-25, бургас-14, буйлс-22, монос-50, тэсмэг-65 тоо ширхэг бүхий нийт 4123 мод бут ургаж байна.





ХОВД АЙМАГ ДАХЬ  
САЛБАР СУРГУУЛЬ

ᠬᠣᠪᠳᠠ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ  
ᠰᠠᠯᠪᠠᠷ ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠢ



Зураг 1. Ховд хотын ногоон байгууламж  
усалгааны системийн зураглал

--- Усалгааны систем

--- Нөөцийн сав байршуулах цэг







ХОВД АЙМАГ ДАХЬ  
САЛБАР СУРГУУЛЬ

Ховд аймаг дахь салбар сургууль

Ховд хотын ногоон байгууламжийн ажилд дээрх байгууллагаас гадна албан байгууллагууд бас оролцдог. Тус хотод үйл ажиллагаа явуулж байгаа 76 төрийн байгууллага 13384.84м<sup>2</sup> талбайг хариуцан ногоон байгууламжийн ажил хийдэг бол, хот тохижуулах газар дангаараа 1193.38м<sup>2</sup>, хувийн хэвшлийн 27 аж ахуйн нэгжийн хариуцсан 3007.54м<sup>2</sup>, гэрээгээр цэцэгжүүлдэг 1627,5м<sup>2</sup> талбайд тус тус ногоон байгууламжийн ажил хийгдэж байна.

*Хүснэгт 1. Ховд хотод ургаж буй мод бутны тоо хэмжээ*

Мод бут бүхий газар	Байгууллагын тоо	Нийт мод бутны тоо
Албан байгууллага, аж ахуйн нэгжийн талбайд таригдсан мод, бут	76	43232
Мод үржүүлгийн газруудад байгаа мод, бутны тарьц суулгац	11	321563
Жаргалант сумын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжид ургаж буй мод бутны тоо		4123







ХОВД АЙМАГ ДАХЬ  
САЛБАР СУРГУУЛЬ

Ховд аймаг дахь  
салбар сургууль

**Хотын төвийн нийтийн эзэмшлийн талбайны 19213,76 м<sup>2</sup>-ыг нь 102 байгууллага аж ахуйн нэгжид хариуцуулсанаас:**

- 29 байгууллага тариалалт арчилгааг бүрэн хийсэн
- 45 байгууллага тариалалт хийсэн боловч арчилгаа хийгээгүй
- 28 байгууллага тариалалт арчилгаа хийгээгүй байна.

**Тариалалт арчилгаа хийгээгүй байгууллагуудыг авч үзвэл:**

- Ажлын ачаалал ихтэй байсан- 6 /ЭМГ, ӨЭМТ/
- Хариуцуулсан талбайд тариалалт хийхээс татгалзсан-5
- Гэрээ байгуулсан ч тариалалт хийгээгүй-11
- Гэрээ хийгээгүй-7





ХОВД АЙМАГ ДАХЬ  
САЛБАР СУРГУУЛЬ

ᠬᠣᠪᠳᠠ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ  
ᠰᠠᠯᠪᠠᠷ ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠤ





ХОВД АЙМАГ ДАХЬ  
САЛБАР СУРГУУЛЬ

ᠬᠣᠪᠳᠤ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ  
ᠰᠠᠯᠪᠠᠷ ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠢ

- Ховд хотын А зэрэглэлийн бүсэд байрлах талбайд 204 ширхэг цэцгийн мандалд цэцэг тарьж, 10846 м<sup>2</sup> талбайд зүлэгжүүлэлт хийгдсэн.
- Ховд аймгийн төсвөөс ногоон байгууламжийн ажил хийх, мод тарихад зориулж жил болгон тодорхой төсөв төсөвлөдөг боловч арчилгаа тордолгоо, усны асуудлаас болоод тарьсан модны тодорхой хувь нь амьдардаг байна.

Мод тарьсан он сар	таригдсан модны тоо		Нийт таригдсан модны тоо	мод тарьсан иргэдийн тоо	Мод тарьсан аж ахуй нэгж, байгууллагын тоо	нийт зарцуулсан зардлын тооцоо
	модны тоо	бут сөөгний тоо				
21.10.09	7256	200	7456	2191	68	11,184,000.00
20.10.10	610	838	1448	724	42	2,496,000.00
20.05.09	2747	1689	4436	841	82	4,432,000.00
19.10.14	2078	200	2278	992	43	2,958,000.00
19.05.14	5845	973	6818	1183	39	4,675,000.00
18.10.15	1585	407	1992	908	42	2,414,000.00
18.05.13	5076	897	5973	1762	84	2,780,000.00
17.05.15	952	5099	6051	1507	53	8,425,500.00
17.10.16	3588	844	4432	1734	60	4,432,000.00
Total	29737	11147	40884	11842	513	43,796,500.00






ХОВД АЙМАГ ДАХЬ  
САЛБАР СУРГУУЛЬ

Ховд аймаг дахь  
салбар сургууль  
Ховд аймаг дахь  
салбар сургууль

Ойн зурвасын талбайн хэмжээ /2016-2022 /







ХОВД АЙМАГ ДАХЬ  
САЛБАР СУРГУУЛЬ

## 2022 онд мод үржүүлэгийн зориулалтаар эзэмшүүлэх газрын байршлын зураг



ᠬᠣᠪᠳᠤ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ  
ᠰᠠᠯᠪᠠᠷ ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠤ







ХОВД АЙМАГ ДАХЬ  
САЛБАР СУРГУУЛЬ

Ховд хот  
ноогоон  
байгууламжид  
хохирол  
учруулсан  
малыг  
хашиж,  
эздэд нь  
хариуцлага  
тооцох  
журмыг  
баталсан.

- Мөн хотын захын хорооллуудаар мал бүхий айлууд нилээд байдаг бөгөөд төвийн ногоон байгууламжийг идэж устгах тохиолдол их байдаг.
- Ховд хот ногоон байгууламжаа хамгаалах үүднээс хотын ногоон бүсэд нэвтэрсэн болон ногоон байгууламжид хохирол учруулсан малыг хашиж, эздэд нь хариуцлага тооцох журмыг баталсан.

ТӨСӨЛ

Жаргалант сумын ИТХ-ын хуралдааны .....  
оны ... дугаар сарын ... -ны өдрийн  
..... тоот тогтоолын хавсралт.

### ХОТЫН НОГООН БҮСЭД НЭВТЭРСЭН БОЛОН НОГООН БАЙГУУЛАМЖИД ХОХИРОЛ УЧРУУЛСАН МАЛЫГ ХАШИЖ, ЭЗДЭД НЬ ХАРИУЦЛАГА ТООЦОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл:

Жаргалант сумын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөө тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уяалдуулан мал аж ахуй эрхлэх болон хориглох бүсийг тогтоох, мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсэд явсан мал амьтныг хашиж журамлах, хотын ногоон байгууламжид учирсан хохирлыг арилгуулах, зөрчил гаргагчидад хариуцлага тооцохтой холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

Хоёр. Мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрөх бүс:

2.1. Жаргалант суманд мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрөх бүсэд дараах газрууд багтана. Үүнд:

2.1.1. Цэвэр усны станцын ус олзборлох таван улаан худгаас дээш нисэх буудлын хамгаалтын торны хойт талаархи газар.

2.1.2. Таван улаан худгаас дээшхи хоёр голын дунд хэсэг болон голын хоёр талаар Бугат үзүүр хүртлэх газар.

2.1.3. Улаан богочийн рашаанаас доош газар.

2.1.4. Их голын хойд тал Аман худаг, Хатуу хөтөл, Оцон чулуу орчим.

2.1.5. Үерийн далангаас урагш Бичигтийн хөтөл чиглэлд.

2.1.6. Нисэх тосгоны урд болон дээд талаар Арын худаг хүртэл газар.

2.1.7. Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид болон мал бүхий иргэдийн хэрэгцээнд зориулан эзэмшүүлсэн газар.

Гурав. Мал аж ахуй эрхлэх, мал бэлчээхийг хориглох бүс:

3.1. Дараах газруудад мал аж ахуй эрхлэх, мал бэлчээхийг хориглоно.

3.1.1. Энэ журмын 2 дугаар зүйлийн 2.1 дахь хэсэгт зааснаас бусад газар.

3.1.2. Их, бага голын гүүрнээс дээш таван улаан худаг хүртэл хоёр голын дунд хэсэгт.

3.1.3. Их, бага голын гүүрнээс доош Улаан богочийн рашаан хүртлэх хоёр голын дунд хэсэг, болон бага голын урд тал.

3.1.4. Ховд хот доторх ногоон байгууламж бүхий нийтийн эзэмшлийн гудамж талбай, нийтийн орон сууц, гэр хорооллын гудамж талбай.

3.1.5. Газар тариалан эрхлэх, жимс жимсгэнэ тариалах, мод үржүүлэх ойжуулалт хийх зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж байгууллагын эзэмшиж ашиглаж буй газрын ойр орчим.

3.1.6. Дөрвийн газрын ойжуулалт болон газар тариалангийн бүсийн ойр орчим.

3.1.7. Малын халдварт болон гоц халдварт өвчин гарч байсан голомтот газрууд. /Хөндийн ам гэх мэт./





ХОВД АЙМАГ ДАХЬ  
САЛБАР СУРГУУЛЬ

ᠬᠣᠪᠳᠠ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ  
ᠰᠠᠯᠪᠠᠷ ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠤ

- Ногоон байгууламж нь хотын өнгө үзэмжийг нэмэгдүүлэхээс гадна эрүүл мэнд, гоо зүйн асар их ач холбогдолтой.

1га талбай дахь мод, сөөг нь 18сая м<sup>3</sup> агаарыг цэвэршүүлнэ. Агаарын бохирдлын 30-35%-г өөртөө шингээнэ.

Навчит мод нь машин техникийн болон бусад дуу чимээний 26%-г замхруулж, тоос шороог 21-76% хүртэл өөртөө барьж хэт халалт ба хөрөлтийг 2-3 хэмээр бууруулдаг





ХОВД АЙМАГ ДАХЬ  
САЛБАР СУРГУУЛЬ


ᠬᠣᠪᠳᠤ

ᠠᠶᠢᠮᠠᠭ

ᠳᠠᠬᠤ

ᠰᠠᠯᠪᠠᠷ

- Ховд хотын хувьд 1500 орчим ачааны, 4000 орчим суудлын автомашинтай, өвөлд 6000 орчим гэр хорооллын өрхтэй, нэг өрх өвөлд 4 т нүүрс түлдэг, 49 100 тонноос дээш нүүрс хэрэглэдэг бага оврын 49 уурын зуухтай, төвлөрсөн уурын зуух 2 байна.
- Энэ бүгдээс харахад ховд хотын агаар ямар хэмжээний угаарын хий, тоос шороогоор бохирддог нь тодорхой байна.
- Иймээс Ховд хотын ногоон байгууламж агаарын бохирдлыг тодорхой хэмжээгээр бууруулж байна.







ХОВД АЙМАГ ДАХЬ  
САЛБАР СУРГУУЛЬ

ᠬᠣᠪᠳᠠ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ  
ᠰᠠᠯᠪᠠᠷ ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠤ

Томоохон хот суурин газруудад нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээ стандарт байдаг.

Хотуудын төрөл	Дэлхийн стандарт	Дэлхийн томоохон хот суурингууд	Улаанбаатар хот	Ховд хот
Нэг хүнд ноогдох ногоон байгууламж	9м <sup>2</sup>	16м <sup>2</sup>	6м <sup>2</sup>	2м <sup>2</sup>

Ховд хотын хүн ам 2021 оны байдлаар 31980 хүрсэн ба 1 хүнд оногдох ногоон байгууламж 2м<sup>2</sup> байна. Үүнийг олон улсын стандартад хүргэхийн тулд хотын ногоон байгууламжийг 3-4 дахин нэмэгдүүлэх шаардлагатай байна.





ХОВД АЙМАГ ДАХЬ  
САЛБАР СУРГУУЛЬ

ᠬᠣᠪᠳᠠ  
ᠠᠶᠢᠮᠠᠭ

ᠳᠠᠬᠤ  
ᠰᠠᠯᠪᠠᠷ

ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠢ

ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠢ

Ховд аймаг нь ногоон байгууламжийг сайжруулах чиглэлээр 2014 онд “НОГООН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР” боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд ногоон хөгжлийн бодлогыг 2 үндсэн үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

- 1 дүгээр үе шат: Ногоон хөгжлийн үндсийг тавих үе, 2014-2020 он;
- 2 дугаар үе шат: Ногоон хөгжилд шилжих үе, 2021-2030 он.

Тус ногоон хөгжлийн хөтөлбөр нь стратегийн 6 зорилт дэвшүүлсэн бөгөөд Ховд хотын эдэлбэр газарт ногоон байгууламжийн эзлэх хувь хэмжээг 2020 он гэхэд 20 хувь, 2030 он гэхэд 30 хувьд хүргэх зорилт тавьсан. Өнөөгийн байдлаар зорилгын биелэлт маш тааруу байгаа.





ХОВД АЙМАГ ДАХЬ  
САЛБАР СУРГУУЛЬ

## Тулгамдсан асуудал:

- Хот тохижуулах газар автомашин, багаж хэрэгсэл дутмаг.
- Одоогийн хувиарлаж байгаа төсөв хөрөнгөөр хотын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх, арчилалт, хамгаалалтыг сайжруулах боломжгүй.
- Малыг хотын төвөөс гаргаж чадахгүй байна. Хотын төвд 70 орчим өрхийн 650 гаран бод мал байна.

ᠬᠣᠪᠳᠠ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ  
ᠰᠠᠯᠪᠠᠷ ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠢ





ХОВД АЙМАГ ДАХЬ  
САЛБАР СУРГУУЛЬ

Ховд аймаг дахь  
салбар сургууль

## ДҮГНЭЛТ

- Ховд хотын нийтийн эзэмшлийн 19213,76 м<sup>2</sup> талбай бүхий 260 тагт, саданд шилмүүст мод-47, жодоо-2, шар хуайс-201, нохойн хошуу-11, хайлаас-3421, улиас-262, голт бор-1, зэгд-2, агч-25, бургас-14, буйлс-22, монос-50, тэсмэг-65 тоо ширхэг бүхий нийт 4123 мод бут ургаж байна.
- Ховд хотын ногоон байгууламжийн ажилд аймгийн Хот тохижуулах газраас гадна албан байгууллагууд бас оролцдог. Тус хотод үйл ажиллагаа явуулж байгаа 76 төрийн байгууллага 13384.84м<sup>2</sup> талбайг хариуцан ногоон байгууламжийн ажил хийдэг бол хот тохижуулах газар дангаараа 1193.38м<sup>2</sup>, хувийн хэвшлийн 27 аж ахуйн нэгжийн хариуцсан 3007.54м<sup>2</sup>, гэрээгээр цэцэгжүүлдэг 1627,5м<sup>2</sup> талбайд тус тус ногоон байгууламжийн ажил хийгдэж байна.







ХОВД АЙМАГ ДАХЬ  
САЛБАР СУРГУУЛЬ

ᠬᠣᠪᠳᠠ  
ᠠᠶᠢᠮᠠᠭ  
ᠳᠠᠬᠤ

ᠰᠠᠯᠪᠠᠷ  
ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠢ

ᠶ᠋ᠢᠨ

ᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠢ

- Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр иргэд идэвхтэй оролцдог уламжлалт арга хэмжээ болж хэвшиж байгаа боловч тарьсан мод, сөөгөнд байнгын арчилгаа, хамгаалалт хийгддэггүйгээс мод, сөөгний ургалт хангалтгүй байна. Иймээс тарьсан мод, сөөг бүртгэлжүүлэх, арчилгаа, хамгаалалтын ажлыг чанаржуулах хэрэгтэй байгааг холбогдох байгууллагууд анхаарах шаардлагатай байна.
- Бэлтгэж байгаа модны үр, тарьц, суулгацын чанарыг сайжруулахад онцгой анхаарч, мод үржүүлгийн газрын үйл ажиллагаанд улсаас дэмжлэг үзүүлж, хөнгөлттэй зээл олгох, далд үндэсний системтэй тарьц суулгацаар ойжуулалт, ойн нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэх ажлуудыг орон нутагт илүү түлхүү хиймээр байна.





ХОВД АЙМАГ ДАХЬ  
САЛБАР СУРГУУЛЬ

Ховд аймаг дахь  
салбар сургууль

## Цаашид хэрэгжүүлэх ажлууд:

- Хот тохижуулах газрын орон тоо бүтцийг нэмэгдүүлэх.
- Хөрөнгө оруулалтын бодлогыг өөрчлөх.
- Малыг хотын төвөөс гаргах ажлыг зохион байгуулах.
- Хөв цөөрөм байгуулах.
- Нийтийн эзэмшлийн авто замд ус зайлуулах инженерчлэлийн байгууламж хийх, хуримтлагдсан усыг ногоон байгууламжийн усалгаанд ашиглах.
- Услалтын системийн хэмжээг нэмэгдүүлэх.





ХОВД АЙМАГ ДАХЬ  
САЛБАР СУРГУУЛЬ

Ховд аймаг дахь  
салбар сургууль







ХОВД АЙМАГ ДАХЬ  
САЛБАР СУРГУУЛЬ

Ховд аймаг дахь  
салбар сургууль








ХОВД АЙМАГ ДАХЬ  
САЛБАР СУРГУУЛЬ

Ховд аймаг дахь  
салбар сургууль



**АНХААРАЛ ХАНДУУЛСАН БАЯРЛАЛАА**

